



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 389

Улаанбаатар хот

“Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах,  
түүнд хяналт тавих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 232 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 6.2, 6.3<sup>1</sup> дахь заалтыг дор дурдсан агуулгатайгаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ “6.2. Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд учирч болзошгүй хохирлын нөөц санг дараах аргачлалаар улирал тутамд байгуулна. Үүнд:

$$\left( \frac{OTX - \text{аас олгосон нөхөн төлбөр} + \text{байгуулсан УБНХНС}}{OTX} \right) * 100\% < X \text{ үед}$$

$$УБНХНС = \left[ X - \left( \frac{OTX - \text{аас олгосон нөхөн төлбөр} + \text{байгуулсан УБНХНС}}{OTX} \right) * 100\% \right] \times OTX$$

Энд,

“ОТХ” – орлогод тооцсон хураамж;

“УБНХНС”- учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан;

“УБХНС” – учирч болзошгүй хохирлын нөөц сан;

“Х” – Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ын 3.1.1-д заасан “Даатгалын цэвэр хураамж”-ийн хувь.

001001

2/ “6.3<sup>1</sup>. Даатгалын цэвэр хураамжийн хувийг жил бүрийн 1 дүгээр сард багтаан даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр тооцож Хороонд ирүүлнэ. Хороо даатгалын цэвэр хураамжийн хувийг тооцож ирүүлснээс хойш 30 хоногийн дотор багтаан хянаж, хариу хүргүүлнэ. Албан журмын даатгалын хувьд цэвэр хураамжийн хувийг Хороо жил бүр тогтооно.” гэж.

2. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын цэвэр хураамжийн хувийг 2012 онд 60 хувиар тогтоосугай.

3. Даатгалын цэвэр хураамжийн хувийг 2013 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Хороогоор хянуулж, 2012 оны жилийн эцэст байгуулах учирч болзошгүй хохирлын нөөцийн санг энэхүү тогтоолын 1 дэх заалтын 1 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу байгуулахыг Даатгалын компаниудад үүрэг болгосугай.

4. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х. Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

